

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2026/028/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Баянхонгор хот
2026 оны 02 дугаар сарын 24

2026

Санхүүгийн аудитын газрын дарга, Тэргүүлэх
аудитор: Ц.Наранчимэг
Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: М.Алтантуяа
Утас: 99061829 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn
Аудитор: Г.Энхзул
Утас: 99333147 Цахим хаяг: enkhzulg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
4. АУДИТЫН ТАЙЛАН	12
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	14
5.1 Төлбөрийн акт.....	15
6.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/278

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн хуралдааны 3/52 дугаар "Хөрөнгөд эзэмшигч тогтоох тухай" тогтоолоор 114,449.4 мянган төгрөгийн цэцэрлэгийн их засварын ажлыг хүлээн авсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Дээд шатны захирагчийн дэргэдэх дотоод аудитын алба нь боловсролын байгууллагуудын урамшуулал олголт, худалдан авах ажиллагаанд хяналт хэрэгжүүлэхгүй байгаа нь тухайн асуудлуудтай холбоотой зөрчил арилахгүй, давтагдан гарах эрсдэлтэй байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгадагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	254,765,238.21	185,295,674.37
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	117,441,356.44	25,263,249.96
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	117,441,356.44	25,263,249.96
3121	Төгрөг	117,441,356.44	25,263,249.96
31211	Төрийн сангийн харилцах	117,441,356.44	25,263,249.96
33	АВЛАГА	00.00	237,900.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	237,900.00
35	БАРАА МАТЕРИАЛ	137,323,881.77	159,794,524.41
354	Хангамжийн материал	137,323,881.77	159,794,524.41
35410	Бичиг хэргийн материал	699,600.00	266,300.00
35420	Аж ахуйн материал	21,392,071.63	21,123,214.27
35450	Барилгын засварын материал	00.00	413,050.00
35460	Хүнсний материал	20,000.00	3,418,900.00
35470	Бусад хангамжийн материал	115,212,210.14	134,573,060.14
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,760,101,876.37	1,790,624,012.47
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,760,101,876.37	1,790,624,012.47
392	Биет хөрөнгө	1,730,701,876.37	1,761,224,012.47
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,870,381,859.76	1,984,831,235.76
39202	Хуримтлагдсан элэгдэл	(263,310,570.96)	(326,463,776.28)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	147,119,944.75	147,619,944.75
39206	Хуримтлагдсан элэгдэл	(70,950,492.24)	(91,601,349.36)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	72,167,297.80	78,522,977.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	(28,198,861.74)	(35,727,719.20)
39217	Ном	3,492,699.00	4,042,699.00
393	Биет бус хөрөнгө	29,400,000.00	29,400,000.00
39301	Програм хангамж	150,000.00	150,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(150,000.00)	(150,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	29,400,000.00	29,400,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,014,867,114.58	1,975,919,686.84
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	13,055,100.00	00.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	13,055,100.00	00.00
413	Өглөг	13,055,100.00	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,582,000.00	00.00
4136	Бусад өглөг	10,473,100.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	10,473,100.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,001,812,014.58	1,975,919,686.84
51	Засгийн газрын хувь оролцоо	2,001,812,014.58	1,975,919,686.84
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	118,876,104.00	118,876,104.00
51101	Өмч: - төрийн	118,876,104.00	118,876,104.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,664,439,124.18	1,638,546,796.44
51210	Өмнөх үеийн үр дүн	1,664,439,124.18	1,674,119,124.18
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	(35,572,327.74)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	218,496,786.40	218,496,786.40
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,014,867,114.58	1,975,919,686.84

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,254,145,284.59	1,486,476,526.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	94,874,084.59	123,150,526.00
120	Нийтлэг татварын бус орлого	94,874,084.59	123,150,526.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	105,000.00	70,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	70,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	105,000.00	00.00

Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,159,271,200.00	1,363,326,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,052,582,900.00	1,218,733,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,052,582,900.00	1,218,733,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	106,688,300.00	144,592,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	106,688,300.00	144,592,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,233,136,614.22	1,522,048,853.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,233,136,614.22	1,522,048,853.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,221,894,749.78	1,505,747,557.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	799,121,706.18	1,031,873,680.66
210101	Үндсэн цалин	798,786,417.18	608,619,252.91
210102	Нэмэгдэл	335,289.00	347,641,600.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	13,785,888.00
210104	Урамшуулал	00.00	61,826,939.75
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	99,033,404.53	121,070,288.82
210201	Тэтгэврийн даатгал	67,412,669.89	83,208,988.82
210202	Тэтгэмжийн даатгал	7,805,390.50	9,528,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,301,244.61	4,766,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,864,228.10	4,766,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	15,649,871.43	18,800,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	100,884,635.56	131,764,766.48
210301	Гэрэл, цахилгаан	11,087,099.56	14,555,346.48
210302	Түлш, халаалт	88,147,536.00	115,409,420.00
210303	Цэвэр, бохир ус	1,650,000.00	1,800,000.00
2105	Нормативт зардал	100,905,475.00	99,375,200.00
210502	Хоол, хүнс	100,905,475.00	99,375,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,044,600.00	9,720,000.00
210604	Урсгал засвар	3,044,600.00	9,720,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,728,900.00	4,305,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	142,800.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,786,100.00	4,305,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	116,176,028.51	107,638,421.26
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,370,697.65	16,288,157.36
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,816,600.00	17,344.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	87,988,730.86	91,332,919.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,241,864.44	16,301,296.52
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,438,200.00	13,473,763.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,438,200.00	13,473,763.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,803,664.44	2,827,533.52
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,803,664.44	2,827,533.52
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	21,008,670.37	(35,572,327.74)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	21,008,670.37	(35,572,327.74)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,159,376,200.00	1,363,396,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	105,000.00	70,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	105,000.00	70,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	105,000.00	70,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	70,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	105,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,159,271,200.00	1,363,326,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,052,582,900.00	1,218,733,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,052,582,900.00	1,218,733,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	106,688,300.00	144,592,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	106,688,300.00	144,592,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,138,520,305.71	1,448,168,426.48

Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,138,520,305.71	1,448,168,426.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,127,278,441.27	1,431,867,129.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	799,070,961.87	1,034,455,680.66
210101	Үндсэн цалин	448,891,952.92	608,619,252.91
210102	Нэмэгдэл	270,856,971.84	347,641,600.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	13,785,888.00
210104	Урамшуулал	79,322,037.11	64,408,939.75
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	99,084,148.84	121,308,188.82
210201	Тэтгэврийн даатгал	67,140,102.33	83,208,988.82
210202	Тэтгэмжийн даатгал	8,082,790.35	9,528,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,111,826.33	4,766,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,816,017.60	4,766,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	15,933,412.23	19,038,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	100,884,635.56	131,764,766.48
210301	Гэрэл, цахилгаан	11,087,099.56	14,555,346.48
210302	Түлш, халаалт	88,147,536.00	115,409,420.00
210303	Цэвэр, бохир ус	1,650,000.00	1,800,000.00
2105	Нормативт зардал	100,089,795.00	102,774,100.00
210502	Хоол, хүнс	100,089,795.00	102,774,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	10,000,000.00
210604	Урсгал засвар	3,000,000.00	10,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,872,800.00	4,628,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,872,800.00	4,628,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	22,276,100.00	26,936,094.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,045,000.00	19,549,750.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,231,100.00	7,386,344.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,241,864.44	16,301,296.52
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,438,200.00	13,473,763.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,438,200.00	13,473,763.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,803,664.44	2,827,533.52
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,803,664.44	2,827,533.52
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	20,855,894.29	(84,772,426.48)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	9,982,000.00	7,405,680.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9,982,000.00	7,405,680.00
2200	Дотоод эх үүсвэрээр	9,982,000.00	7,405,680.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	9,982,000.00	7,405,680.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(9,982,000.00)	(7,405,680.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	10,873,894.29	(92,178,106.48)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	106,567,462.15	117,441,356.44
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	117,441,356.44	25,263,249.96

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	118,876,104.00	218,496,786.40	1,643,430,453.81	1,980,803,344.21
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	118,876,104.00	218,496,786.40	1,643,430,453.81	1,980,803,344.21
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	21,008,670.37	21,008,670.37
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	118,876,104.00	218,496,786.40	1,664,439,124.18	2,001,812,014.58
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	9,680,000.00	9,680,000.00

Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дахин илэрхийлсэн үлдэгдэл	118,876,104.00	218,496,786.40	1,674,119,124.18	2,011,492,014.58
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	(35,792,883.74)	(35,792,883.74)
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	118,876,104.00	218,496,786.40	1,638,326,240.44	1,975,699,130.84

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /Улсын төсөв/

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,326,326,000.00	1,310,964,462.48	15,361,537.52	98.84
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,220,298,400.00	1,218,733,700.00	1,564,700.00	99.87
Улсын төсвөөс санхүүжих	1,220,298,400.00	1,218,733,700.00	1,564,700.00	99.87
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	106,027,600.00	92,230,762.48	13,796,837.52	86.99
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	567,700.00	70,000.00	497,700.00	12.33
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	105,459,900.00	92,160,762.48	13,299,137.52	87.39
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,326,326,000.00	1,310,964,462.48	15,361,537.52	98.84
УРСГАЛ ЗАРДАЛ	1,326,326,000.00	1,310,964,462.48	15,361,537.52	98.84
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,312,852,200.00	1,297,490,699.48	15,361,500.52	98.83
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,041,856,100.00	1,034,455,680.66	7,400,419.34	99.29
Үндсэн цалин	643,696,200.00	608,619,252.91	35,076,947.09	94.55
Нэмэгдэл	348,145,700.00	347,641,600.00	504,100.00	99.86
Унаа хоолны хөнгөлөлт	00.00	13,785,888.00	(13,785,888.00)	0.00
Урамшуулал	50,014,200.00	64,408,939.75	(14,394,739.75)	128.78
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	127,893,600.00	121,308,188.82	6,585,411.18	94.85
Тэтгэврийн даатгал	86,458,300.00	83,208,988.82	3,249,311.18	96.24
Тэтгэмжийн даатгал	10,358,700.00	9,528,400.00	830,300.00	91.98
ҮОМШӨ-ний даатгал	5,179,500.00	4,766,200.00	413,300.00	92.02
Ажилгүйдлийн даатгал	5,179,500.00	4,766,200.00	413,300.00	92.02
Эрүүл мэндийн даатгал	20,717,600.00	19,038,400.00	1,679,200.00	91.89
Нормативт зардал	103,582,000.00	102,774,100.00	807,900.00	99.22
Хоол, хүнс	103,582,000.00	102,774,100.00	807,900.00	99.22
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,628,300.00	4,628,300.00	0.00	100.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,628,300.00	4,628,300.00	0.00	100.00
Бараа үйлчилгээний бусад зардал	34,892,200.00	34,324,430.00	567,770.00	98.37
Бараа үйлчилгээний бусад зардал	26,973,200.00	26,405,430.00	567,770.00	97.90
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,919,000.00	7,919,000.00	0.00	100.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,473,800.00	13,473,763.00	37.00	100.00
Бусад урсгал шилжүүлэг	13,473,800.00	13,473,763.00	37.00	100.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,473,800.00	13,473,763.00	37.00	100.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	117,441,356.44	(117,441,356.44)	0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	25,263,249.96	25,263,249.96	0.00
АЖИЛЛАГСДЫН ТОО	45	36	9	80.00
Удирдах ажилтан	3	1	2	33.33
Гүйцэтгэх ажилтан	25	25	0	100.00
Үйлчлэх ажилтан	17	10	7	58.82

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Цэцэрлэг нь бага насны хүүхдийг асран хамгаалах, хүмүүжүүлэх сургах цогц үйл ажиллагаа явуулж хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмших хөгжлийг дэмжих, сургуульд орох бэлтгэлийг хангах чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг.

Тус байгууллага нь “Хүүхэд нэг бүрийг хөгжүүлнэ. Сайн туршлага, сайн үйл ажиллагаагаараа бусдад танигдаж улмаар улсын тэргүүний цэцэрлэг болох” гэсэн зорилгын дор Боловсрол, шинжлэх ухааны яамнаас жил бүр дэвшүүлэн тавьсан зорилтыг хангах үүднээс байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах чиг үүргийн дагуу Эрхлэгчийн 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/01 дугаар тушаалаар 45 орон тоо батлагдаж, 36 орон тоотой, 9 үндсэн бүлэгт 200 хүүхдийг хамруулан цэцэрлэгийн үйл ажиллагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үнэллээ.

Тайлант онд Боловсролын Ерөнхий газар болон аймгийн Боловсролын газраас хяналт шалгалт хийгдээгүй ба аймгийн Санхүүгийн хяналт дотоод аудитын газраас хийгдсэн шалгалтаар хэвийн гэж дүгнэгдсэн байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Цэцэрлэг нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь аймгийн Санхүү, Төрийн сангийн хэлтсээс баталсан “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишиг баримт бичиг”-ийг дагаж мөрдөж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Цэцэрлэг нь 2025 оны санхүүгийн тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 1,975,919.7 мянган төгрөг болж өмнөх оноос 38,947.4 мянган төгрөг буюу 1.9 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	254,765.2	185,295.7	(69,469.6)
Мөнгөн хөрөнгө	117,441.4	25,263.2	(92,178.1)
Авлага	-	237.9	237.9
Бараа материал	137,323.9	159,794.5	22,470.6
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,760,101.9	1,790,624.0	30,522.1
Үндсэн хөрөнгө	2,122,711.8	2,244,566.9	121,855.1
Хуримтлагдсан элэгдэл	(362,609.9)	(453,942.8)	(91,332.9)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,014,867.1	1,975,919.7	(38,947.4)
Өр төлбөр	13,055.1	-	(13,055.1)
Засгийн газрын хувь оролцоо	2,001,812.0	1,975,919.7	(25,892.3)
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,014,867.1	1,975,919.7	(38,947.4)

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 25,263.2 мянган төгрөг болж өмнөх оноос 92,178.1 мянган төгрөг буюу 78.5 хувиар буурсан нь тайлант онд өмнөх оны үлдэгдлээс зарцуулахаар батлагдаж зарцуулсантай холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 237.9 мянган төгрөг нь ажилчидтай холбоотой авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 159,794.5 мянган төгрөг болж өмнөх оноос 22,470.6 мянган төгрөг буюу 16.4 хувиар өссөн байна. Тайлант онд бараа материал төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 131,277.1 мянган төгрөгөөр, шилжүүлэн авсан 8,631.2 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, зарцуулсан 111,168.7 мянган төгрөгөөр байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн шийдвэрээр акталсан 268.9 мянган төгрөгөөр тус тус хасагдсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,244,566.9 мянган төгрөг болж өмнөх оноос 121,855.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 7,405.7 мянган төгрөгөөр, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн хуралдааны 3/52 дугаар "Хөрөнгөд эзэмшигч тогтоох тухай" тогтоолоор цэцэрлэгийн их засварын төсөл, арга хэмжээний үр дүнд 114,449.4 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Богино хугацаат өр төлбөр дансны эхний үлдэгдэл байгууллагад төлөх 10,473.1 мянган төгрөг, ажилчидтай холбогдсон 2,582.0 мянган төгрөгийн өглөгийг тайлант хугацаанд бүрэн барагдуулсан байна.

Тус байгууллага нь Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ны Acolous accounting system 4.0 санхүүгийн программ хангамжийг санхүүгийн үйл ажиллагаандаа ашигладаг байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,251,402.0 мянган төгрөгөөр тооцон зардлыг санхүүжүүлэхээр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 33,356.9 мянган төгрөгөөр бууруулж, урьд оны үлдэгдлээс 103,164.8 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, 1,321,209.9 мянган төгрөгөөр баталсныг төсвийн тодотголоор 1,326,326.0 мянган төгрөгөөр тодотгожээ.

Орон нутгийн төсвөөс тогтмол зардалд 144,592.3 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр батлагджээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвөөс 1,326,326.0 мянган төгрөгийн санхүүжилт олгогдсоноос урсгал үйл ажиллагаанд 1,310,964.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт /хувь/
1	80233 Хүүхэд хамгаалал	1,913.5	1,913.5	0.0	100.0
2	81605 Эрүүл мэндийг дэмжих	1,733.0	1,733.0	0.0	100.0
3	81807 Цэцэрлэгийн хүүхдийн хоол	103,078.0	102,270.1	807.9	99.2
4	81816 Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	3,226.6	3,226.6	0.0	100.0
5	81823 Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	1,529.8	1,529.8	0.0	100.0
6	81832 Нүүдлийн бүлэгт хамруулах	4,291.0	3,450.2	840.8	80.4
7	81834 Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх	1,153,097.6	1,145,986.4	7,111.2	99.4
8	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагаа	56,888.8	50,854.8	6,034.0	98.3
9	81844 Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	567.7	-	567.7	-
	Нийт дүн	1,326,326.0	1,310,964.5	15,361.5	87.5

Орон нутгийн төсвөөс 144,592.3 мянган төгрөгийн санхүүжилт олгогдож байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 131,764.8 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 10,000.0 мянган төгрөг нийт 141,764.8 мянган төгрөгийг зарцуулж, 2,827.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Тус байгууллага нь Боловсролын сайдын 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн "Чиглэл хүргүүлэх тухай" 1/554 тоот албан бичгийг үндэслэн байгууллагын даргын 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн "Багш, ажилчдад хоолны зардал олгох тухай" А/11 дугаар тушаалаар өдөрт 5.0 мянган төгрөгөөр буюу нийт 13,785.9 мянган төгрөгийн хоолны хөнгөлөлтийг олгосон байна.

Бүтэц орон тоог Боловсрол, шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/85, А/34 дүгээр хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралт дахь "Төрийн болон орон нутгийн өмчийн хүүхдийн цэцэрлэгийн багш, ажилтны орон тооны хязгаарын жишиг норматив"-д заасныг үндэслэн Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Цэцэрлэгийн эрхлэгчийн 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар удирдах 3, гүйцэтгэх 42 албан тушаалтны орон тоог баталж, төсвийн тодотголоор орон тоог бууруулаагүй, гүйцэтгэлээр 36 орон тоотой 1,034,455.7 мянган төгрөгийн цалингийн сантай, 9 орон тоо дутуу ажиллаж байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд хүүхдийн хоол хүнсний бүтээгдэхүүний зардлын 91,743.0 мянган төгрөгийн худалдан авалтыг харьцуулалтын аргаар, хичээл практикийн зардлын 8,288.3 мянган төгрөг, эрүүл мэндийг дэмжих зардлын 1,904.4 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийхээр төлөвлөж, харьцуулалтын аргаар 90,348.0 мянган төгрөгийн хүүхдийн хоол хүнсний материал нийлүүлэх гэрээ, эрүүл мэндийг дэмжих зардалд 1,380.0 мянган төгрөг, хичээл практикийн зардалд 7,919.0 мянган төгрөгөөр шууд худалдан авалт хийж гэрээ байгуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Цэцэрлэг нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл

Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Энхзул гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор Б.Нарангэрэл, аудитын менежер М.Алтантуяа, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Сонгосон суурь үзүүлэлт болох 2025 оны анхны батлагдсан төсөв 1,321,209.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцож 13,212.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуульд хамаарах асуудал байхгүй бөгөөд тогтмол зардлыг 100 хувь зарцуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2025 онд 171 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 163 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан бөгөөд 3 мэдээллийг хугацаа хоцроосон шалтгаан нь 2025 оны төсөв хугацаандаа ирээгүй тул худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хоцроож, 5 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

Тайлант онд шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,325,204.0 мянган төгрөгийн 41 гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын

Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

224,894.7 мянган төгрөгийн 21 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 222,747.8 мянган төгрөгийн 3 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант хугацаанд 2025 оны 3 дугаар улирлын байдлаар завсрын аудитыг хийж гүйцэтгэсэн. Аудитаар 1,230.8 мянган төгрөгийн 2 алдаа зөрчил илэрч, завсрын аудитаар залруулав. Үүнд:

- Тайлант оны 05 дугаар сарын 3-р хагасаар хоолны мөнгө бодож олгосон цалингийн 442.8 мянган төгрөгийн ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг мэдээлээгүй байсан тул нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн мэдээлүүлсэн.
- Аж ахуйн тайлангийн 09 дүгээр сард 284.0 мянган төгрөгийн аж ахуйн материалыг нягтлан бодох бүртгэлд дутуу тусгасан, хүнсний тайлангийн орлого, зарлага 504.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байсан тул санхүүгийн тайланд залруулав.

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг “Номгон аудит” ХХК гүйцэтгэж, аудитаар 7,803.9 мянган төгрөгийн 4 албан шаардлага, 3,425.8 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоосон ба тус байгууллагаас 2025 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 38 дугаартай албан бичгээр аудитын шийдвэрийн хэрэгжилтийг ирүүлснийг хянаж үнэлсэн.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	4	7,803.9	4	7,803.9	100%
Төлбөрийн акт	2	3,425.8	2	3,425.8	100%
Нийт дүн	6	11,229.7	6	11,229.7	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 237.9 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулав. Үүнд:

1. Тайлант онд нийгмийн даатгалын шимтгэлийн илүү төлсөн 237.9 мянган төгрөгийг санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 4 дүгээр зүйлийн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

4.1.1, УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Аудитаар нийт 3,122.5 мянган төгрөгийн 2 зөрчил илэрсэнд төлбөрийн акт тогтоов.

Нийт 3,122.5 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшингээс бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Цэцэрлэгийн хүүхдийн хоолны материал нийлүүлэх тендерт шалгарч материал нийлүүлэх гэрээ хийсэн "Үүрээр цацрах ХХК"-аас нийлүүлсэн бараа материалыг гэрээний үнийн дүнтэй тулган шалгахад 589.0 мянган төгрөгийн үнийн дүнгийн зөрүүтэй худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Бууцагаан сумын Цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсний материал нийлүүлэхээр захиалагч нийлүүлэгчийн хооронд байгуулсан гэрээний 2 дугаар зүйлийн 2.1-д "Захиалагч нь барааны нийлүүлэлтийн үнэ болох 90,348.0 мянган төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр сар бүрийн сүүлээр гүйцэтгэлээр нь санхүүжүүлнэ" гэсэн заалтыг тус тус дагаж мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээний үнийн дүнгээс илүү төлсөн 589.0 мянган төгрөгийг төсвийн захирагч, нягтлан бодогч нараар 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

5.1.2 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш нарт нэмэгдэл хөлсийг олгохдоо 20 хувиар 2,533.5 мянган төгрөгөөр илүү олгосон байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 6 дугаар сарын 01-ний өдрийн 208 дугаар тогтоолын 2.8-д "Ердийн хэв шинжтэй цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш, туслах багшид хүүхдийн хөгжлийн ахиц, багшийн ачааллыг харгалзан түүний албан тушаал (үндсэн)-ын цалингийн 10 хувиар нэмэгдэл хөлс олгоно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон 2,533.5 мянган төгрөгийг төсвийн захирагч, нягтлан бодогч нараар 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд нийгмийн даатгалын шимтгэлийн илүү төлсөн 237.9 мянган төгрөгийг санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна.	1	237.9	1	237.9			1	237.9		
Дүн	1	237.9	1	237.9			1	237.9		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цэцэрлэгийн хүүхдийн хоолны материал нийлүүлэх тендерт шалгарч материал нийлүүлэх гэрээ хийсэн "Үүрээр цацрах ХХК"-иас нийлүүлсэн бараа материалыг гэрээний үнийн дүнтэй тулган шалгахад 589.0 мянган төгрөгийн үнийн дүнгийн зөрүүтэй худалдан авалт хийсэн байна.	1	589.0	1	589.0								
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш нарт нэмэгдэл хөлсийг олгохдоо 20 хувиар 2,533.5 мянган төгрөгөөр илүү олгосон байна.	1	2,533.5	1	2,533.5								
Нийт дүн	2	3,122.5	2	3,122.5								

-----oOo-----



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 23/20571284/БТГА-2026/028/НА-СТХ-Номгон
ТМЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цэцэрлэгийн хүүхдийн хоолны материал нийлүүлэх тендерт шалгарч материал нийлүүлэх гэрээ хийсэн “Үүрээр цацрах ХХК”-иас нийлүүлсэн бараа материалыг гэрээний үнийн дүнтэй тулган шалгахад 589,000 (Таван зуун наян есөн мянган) төгрөгийн үнийн дүнгээр илүү худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Баянхонгор аймгийн Бууцагаан сумын цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсний материал нийлүүлэхээр захиалагч нийлүүлэгчийн хооронд байгуулсан гэрээний 2 дугаар зүйлийн 2.1 дэх заалт “Захиалагч нь барааны нийлүүлэлтийн үнэ болох 90,348,000 төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр сар бүрийн сүүлээх гүйцэтгэлээр нь санхүүжүүлнэ” гэсэн заалтыг тус тус дагаж мөрдөөгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

6426110069

/documents/2026 он/1. бичиг
хэрэг/тоот/4. албан шаардлага 2026.docx

1. Гэрээний үнийн дүнгээс илүү төлсөн 589,000 (Таван зуун наян есөн мянган) төгрөгийг төсөв захирагч, нягтлан бодогч нараар нөхөн төлүүлж Төрийн сан дахь 100030000947 тоот төгрөгийн дансанд төвлөрүүлж, зөрчлийг арилгасан талаарх нотлох баримтыг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Цэцэрлэгийн эрхлэгч Д.Гэрлээ, нягтлан бодогч Т.Мөнхжаргал нарт даалгав^{1,2}.

ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН³:

АУДИТЫН МЕНЕЖЕР:

М.АЛТАНТУЯА

АУДИТОР:

Г.ЭНХЗУЛ



¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

² Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

³ Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 24/10571284 / БНА-2026/028 / Номгон
НА-СТА-ТЦЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Цэцэрлэгийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш нарт нэмэгдэл хөлсийг олгохдоо 20 хувиар нэмэгдүүлэн 2,533,500 (Хоёр сая таван зуун гучин гурван мянга таван зуун) төгрөгөөр илүү олгосон байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн 208 дугаар тогтоолын 2.8 дэх "Ердийн хэв шинжтэй цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш, туслах багшид хүүхдийн хөгжлийн ахиц, багшийн ачааллыг харгалзан түүний албан тушаал (үндсэн)-ын цалингийн 10 хувиар нэмэгдэл хөлс олгоно" гэсэн заалтыг дагаж мөрдөөгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү олгосон 2,533,500 (Хоёр сая таван зуун гучин гурван мянга таван зуун) төгрөгийг төсөв захирагч, нягтлан бодогч нараар нөхөн төлүүлж Төрийн сан дахь 100030000947 тоот төгрөгийн дансанд төвлөрүүлж, зөрчлийг арилгасан талаарх

нотлох баримтыг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Бууцагаан сумын Цэцэрлэгийн эрхлэгч Д.Гэрлээ, нягтлан бодогч Т.Мөнхжаргал нарт даалгав^{1,2}.

ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН³:

АУДИТЫН МЕНЕЖЕР:

М.АЛТАНТУЯА

АУДИТОР:

Г.ЭНХЗУЛ



¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

² Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

³ Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно